



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/025

Өлгий

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", 29.2, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны А/011, А/020 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн түвшинд үйл ажиллагаа эрхэлж буй Хүүхэд харах үйлчилгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Боловсрол, соёл, урлагийн газарт хүлээлгэж өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	К.Бекжан	-ЗДТГ-ын НБХэлтсийн дарга
Гишүүдэд:	Р.Авижат	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Нансалмаа	-Аймгийн ГБХЗХГ-ын дарга
	Х.Зауре	-Аймгийн БСУГ-ын дарга
	Б.Ерген	-Аймгийн ГБХЗХГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн
	Х.Аяужан	-БСУГ-ын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн
	Ж.Өзгөр	-ГБХЗХГ-ын ня-бо
	Н.Мухтар	-БСУГ-ын ня-бо
Нарийн бичгийн дарга	Ш.Сайрангүл	-БСУГ-ын статистик мэдээ, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

2. Хүүхэд харах үйлчилгээний хууль журам стандарт, гарын авлага, мэдээллийн сан, санхүүжилтийн тайлан, байршлын жагсаалт, хяналт үнэлгээний тайлан болон зөвлөмжийг ажил хүлээлцэх маягтын дагуу Боловсрол, соёл, урлагийн газарт нэгбүрчлэн хүлээлгэж өгөхийг ажлын хэсэг /К.Бекжан/-т үүрэг болгосугай.

3. Хүүхэд харах үйлчилгээний ажлын хэсгийн хууль журам, стандартын дагуу явуулахыг Боловсрол, соёл, урлагийн газар /Х.Зауре/-т даалгасугай.

